

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР



БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ



Арын сайхан хангайнхаа хүн ардынхаа эрүүл энхийн ээлжгүй манаанд зогсож, эмнэлгийн байгууллагыг хөгжүүлэх үйлсэд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулсан үеийн ахмадууд, тэдний үйл хэрэг, ажил мэргэжлийг залгамжлан тус аймагт ажиллаж байсан болон одоо ажиллаж буй салбарынхаа эмч, сувилагч, нийт ажилтнууддаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Хүн ардынхаа эрүүл мэндийг сахин хамгаалах, дэмжих эрхэм хүндтэй, хариуцлагатай үүрэг хүлээсэн манай эмч, мэргэжилтэн, ажилтнууд ард иргэддээ үеийн үед цаг мөчтэй уралдан өөрсдийн мэргэжлийн ур чадвар, сэтгэл оюунаа дайчлан зориулж ирсэн түүхээ хадгалж эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй чанартай хүргэхийн төлөө бүхий л бололцоогоо дайчлан зүтгэж, анагаах ухааны орчин үеийн шинэ техник, технологийн дэвшлийг оношилгоо, эмчилгээндээ нэвтрүүлж, мэдлэг боловсрол, ур чадвараа дээшлүүлэн нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг өргөжүүлэх талаар түлхүү анхаарч ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарын суурь шинэчлэлийг цогцоор шийдвэрлэн ажиллах зорилтыг дэвшүүлэн тодорхой ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд цаашид бид ололт амжилтаа улам бататгаж, алдаа оноогоо нягтлан дэнсэлж, эмч, эмнэлгийн ажилтны ёс зүйгээ чанадлан сахиж, энэрэнгүй үйлсийнхээ эрч хүчийг нэмэгдүүлж, эмнэлэг, эмч, эмнэлгийн ажилтныхаа нэр хүндийг улам өндөр өргөн ард иргэдийнхээ итгэлийг хүлээн ажиллана гэдэгт итгэж байна.

Эмч ажилчдын минь үйлс нь бүтэмжтэй, амьдрал нь ямагт өөдрөг, эрүүл энх аз жаргалтай байх болтугай.

*Эрүүл мэндийн газрын дарга,
Анагаах ухааны доктор,
клиникийн профессор* *Р.Гандиймаа*

Тусламж

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ЗОРИЛГО ЗОРИЛТ

АЛСЫН ХАРАА

“Эрүүл хүн ам- Чанартай тусламж”

ЭРХЭМ ЗОРИЛГО

Үр дүнтэй манлайлал бүхий хамт олныг бүрдүүлэн байгууллагын хөгжлийг хангаж, харьяа нутгийн хүн амд эрүүл мэндийн ээлтэй, чанартай, цогц тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар орон нутгийн хөгжил, амьдралын чанарыг сайжруулах

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

- Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдэд ээлтэй, нээлттэй байх
- Эрүүл энх, эрх тэгш байх
- Чанартай, хүртээмжтэй, цогц байх
- Ёс зүйтэй, мэдрэмжтэй байх
- Өндөр мэргэшсэн, сайн чадавхитай байх

ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА БАРИМТАЛДАГ ЗАРЧИМ

- Хөдөө орон нутгийн болон эмзэг, ядуу бүлгийн хүн амд түлхүү анхаарах
- Олон нийтийн санал хүсэлт, эрэлт хэрэгцээ, нотолгоонд тулгуурлах
- Эрх тэгш, нээлттэй сайн түншлэлтэй байх
- Чадавхитай, ёс зүйтэй, харилцааны соёлтой хариуцлагатай ажиллах
- Тасралтгүй, тогтвортой, үр дүнтэй, үр ашигтай байх
- Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн анхан шатны тусламжийн хандлагыг баримтлах



ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БҮТЭЦ ЗОХИН БАЙГУУЛАЛТ

Архангай аймгийн Эрүүл мэндийн газар нь аймгийн Нэгдсэн эмнэлэг, ЗӨСТ, 19 сумын эрүүл мэндийн төв, 3 өрхийн эрүүл мэндийн, хувийн хэвшлийн ортой 6, рашаан сувилал 4, 20 үүдэн эмнэлэг, 64 эмийн сан зэрэг нийт 118 эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.



Архангай аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/138 дугаар “Аймгийн Эрүүл мэндийн газрын дүрэм, бүтэц, орон тоог батлах тухай” захирамжаар бүтэц орон тоо шинэчлэгдэн дараах 5 хэлтэс, 57 албан хаагчтайгаар батлагдсан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс

Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
2. Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
3. Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
4. Сувилахуй, ахмад настан, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
5. Эмийн бодлого, хангамж, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
6. Гамшиг, яаралтай тусламж, цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
7. Уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
8. Эмийн дефектар

НЭМ-ийн хэлтэс

Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

1. Эрүүл мэндийн боловсрол, сургалт суртчилгаа хариуцсан мэргэжилтэн
2. Орчны эрүүл мэнд, БЗДХ/ДОХ/ Сүрьеэгийн сэргийлэлт, тандалт хариуцсан мэргэжилтэн
3. Өсвөр үе, залуучуудын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
4. Халдварт бус өвчний сэргийлэлт, эрт илрүүлэг хариуцсан мэргэжилтэн
5. Халдварт өвчин, эмнэлгийн дотоод халдвар, дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн
6. Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
7. Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
8. Дархлаажуулалтын бага эмч
9. Өсвөр үеийн зөвлөгч бага эмч
10. Өсвөр үеийн хүлээн авагч сувилагч
11. Хэвлэл мэдээлэл, номын сан, сургалтын танхим хариуцсан ажилтан

Удирдлага, төлөвлөлт санхүүгийн хэлтэс

Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга

1. Эрүүл мэндийн эдийн засаг, хөрөнгийн бүртгэл, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
2. Салбарын болон байгууллагын санхүүгийн бүртгэл, нягтлан бодох мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлт, хангалт, барилга, техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
4. Хууль эрх зүй, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага хариуцсан мэргэжилтэн

Үйлчилгээний алба/Удирдлага төлөвлөлтийн санхүүгийн хэлтэст харъяалагдана

1. Даргын туслах, архивын эрхлэгч
2. Бичиг хэргийн ажилтан
3. Нярав
4. Жолооч
5. Үйлчлэгч
6. Цахилгаачин, слесарь
7. Сахиул

Дүн шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс

Хэлтсийн дарга, эрүүл мэндийн статистик, бүртгэл, мэдээлэл хариуцсан/улсын байцаагч/

1. Эрүүл мэндийн хяналт, шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
2. Мэдээллийн технологич
3. Статистикч бага эмч, операторчин
4. Хавдар бүртгэгч, операторчин

Хяналт шалгалтын хэлтэс

Хэлтсийн дарга, эмчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагч

1. Хүүхдийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч
2. Хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч
3. Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч
4. Орчны эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч

даатгалын сангаас санхүүжүүлэх хөрөнгө, нөөцийг бүрдүүлэх, төсвийн хүрэлцээ, тэнцвэртэй байдлыг хангах.

- ✚ Нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн болон эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангаж, эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээг тодорхойлон төлөвлөлт хийх, хангах, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг сайжруулах, тасралтгүй хөгжих болмжийг бүрдүүлэх, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах.
- ✚ Орон нутгийн түвшинд эмнэлгийн барилга, эм эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, автомашины ашиглалт, засвар үйлчилгээ, нөхөн хангалтыг хийх, оновчтой хувиарлах нэгтгэн зохицуулах.
- ✚ Эрүүл мэндийн байгууллагуудын статистик мэдээллийн ажлыг сайжруулж, ажлын нэгдсэн удирдлага, арга барилаар ханган, мэдээллийг төвлөрүүлэх, статистик боловсруулалт хийх.

Эрүүл мэндийн газрын статистик мэдээ мэдээлэл: 1999 оноос Эрүүл мэндийн газарт статистик мэдээллийн тасаг болж өргөжин 1 их эмч, 3 бага эмчтэй ажиллаж байснаа 2010 оноос ЭЗУМХ-ийн чиг үүрэгт харьяалагдан 1 их эмч, 2 бага эмч ажиллаж эхэлсэн. Нэгдсэн эмнэлгийн бүх тасаг, сумын эмнэлэг, өрх, хувийн эмнэлгүүд компьютертэй болж мэдээ мэдээллийг нэгжүүд дээрээ шивж сар улирлын бүх мэдээ мэдээллийг цахим хэлбэрээр ЭМГ-ын статистик мэдээллийн ажилтанууд авч нэгтгэн боловсруулалт хийн ЭМХТ-д мэдээлж байна. Статистик мэдээллийн үйл ажиллагаанд 2003 оноос эрүүл мэндийн Health- Info программаар мэдээ тайлангаа гарган ажиллаж 2002-2003 онуудад улсад тайлан тушаалтаар 3-р байр, 2004 онд 2-р байр, 2005 онд 1-р байранд тус тус шалгарч мөнгөн шагналаар шагнуулж байсан нь бүртгэл мэдээллийн чиглэлээр ажиллаж байгаа төв, хөдөөгийн статистикч бага эмч нарын маань ажлын үр дүн юм. Статистикийн мэдээ мэдээллийн үйл ажиллагаанд одоо төв хөдөөгийн нийт 60 гаруй мэдээ, мэдээлэл хариуцсан менежерүүд ажиллаж байна.

- их эмч Т.Баясгалан 1997-2012 онд
- их эмч Г.Баяртогтох 2013 он – 2018 он
- бага эмч Д.Оюун 1995 -1999 он
- бага эмч Б.Саранцэцэг 1995-2007 он
- бага эмч А.Алтанчимэг 2000-2001 он
- бага эмч З.Баярсайхан 2002-2004 он
- бага эмч Т.Батгэрэл 1998 он-Одоог хүртэл
- бага эмч А.Амгалан 2006 он-Одоог хүртэл
- хавдар бүртгэгч Б.Долормаа 2024 оноос
- их эмч З.Оюунгэрэл 2018 он-Одоог хүртэл

АЖ АХУЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭСЭГ НЬ:

Эрүүл мэндийн газрын Аж ахуй, үйлчилгээний хэсэг нь үндсэн 3 хэлтсийн мэргэжлийн тусламжийг хэвийн явуулахад туслах, нийтлэг үйлчилгээгээр хангах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Аж ахуй, үйлчилгээний хэсэг нь байгууллагын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцлийг бүрэн ханган ажиллана.

Дараах чиг үүрэгтэй:

- ✚ Байгууллагын албан бичиг хэрэг хөтлөлт, архивын бичиг баримтын хадгалалтыг стандартыг дагуу гүйцэтгэх.
- ✚ ЭМГ-ын сургалтын А, Б зааланд сургалт явуулах нөхцлийг хангах, заалны техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах.

- ✚ Байгууллагын эд аж ахуй бүрэн бүтэн байдлыг хангах.
- ✚ Байгууллагын хэвийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад санхүүгийн болон эд материалын хангалтыг хариуцах.
- ✚ Байгууллагын орчны эрүүл ахуй, тохижилт үйлчилгээг хариуцах.
- ✚ Байгууллагын автомашины бүрэн байдлыг хангах, бэлэн байдлыг хангах. Томилолтын хугацаанд мэргэжилтэнүүдийн аюулгүй, байдлыг хангах.



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭЛТЭС



Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, эрүүл мэндийг дэмжих, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөр төслүүдийг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулан ажилладаг.

Хэлтсийн дарга Э.Ариун-Эрдэнэ нь 2010 онд ЭМШУИС-ийн НЭМ-ийн сургуулийг Нийгмийн эрүүл мэнд судлаач, Эрүүл ахуйч мэргэжлээр төгсөн, 2016 онд Номхон далайн баруун эргийн орнуудын ДЭМБ-ын салбарт “Олон улсын Нийгмийн эрүүл мэнд судлал”-аар мэргэжил дээшлүүлсэн. АШУУИС-ийн НЭМ-ийн сургуулийн сайбер магистрийн хөтөлбөрт НЭМ удирдлагын магистрантаар суралцаж байна.

Өмнөговь аймгийн Оюутолгой компанид 2010-2011 онд Эрүүл ахуйч, ХАБЭА-н ажилтан, 2012 онд Орхон аймгийн Эрүүл мэндийн газар тархвар судлаач эмчээр, 2013-2023 онд Архангай аймгийн Эрүүл мэндийн газрын НЭМ-ийн хэлтсийн мэдээлэл сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, 2023 оноос НЭМ-ийн хэлтсийн даргаар тус тус ажиллаж байна.

Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс нь дараах чиг үүрэгтэй:

- ✚ Орон нутгийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн талаар тавих зорилт, стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлон мэргэжлийн удирдлага, үйл ажиллагааны нэгдсэн бодлогоор хангах.

- ✦ Хүн амын эрүүл мэндийн хамгаалах, дэмжих талаар гарсан Монгол улсын хууль тогтоомж, дүрэм, заавар, стандартыг мөрдлөгө болгон төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эрүүл мэндийн бодлогыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх
- ✦ Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаандаа хүн амыг өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг давуутай хөгжүүлэх бодлого, чиглэл баримтлан ажиллах.
- ✦ Нутаг дэвсгэрийн хэмжээнд салбар дундын зохицуулалт хийж, нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалахад нутгийн захиргаа, эрүүл мэндийн бус салбар, олон нийтийн байгууллага, хүн амыг идэвхитэй оролцуулан ажиллах.



ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС



Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс нь орон нутгийн эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж ээлтэй байдлыг сайжруулах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, улс болон хувийн хэвшлийн эмнэлгийн түншлэлийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.

Өнөрсайхан овогтой Мөнхшүр нь 2005 онд АШУИС-ын Сувилахуйн сургуулийг Сувилахуйн аргазүйч мэргэжлээр төгссөн. 2011 онд Ач АУИС-ыг Хүүхдийн их эмч мэргэжлээр төгссөн. 2019 онд Хүүхдийн уушгины эмчээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн. 2022 онд Ахлах зэрэг хамгаалсан.

2005-2007 оны хооронд Цэнхэр сумын эмнэлэгт Алтан овоо багийн эмч, ээлжийн сувилагчаар ажиллаж байсан.

2011-2020 он хүртэл Цэнхэр сумын Эрүүл мэндийн төвд Хүүхдийн их эмчээр ажиллаж байсан.

2020-2023 оны хооронд Цэнхэр сумын Эрүүл мэндийн төвийн даргаар ажиллаж байгаад 2023 оны 06 дугаар сараас одоог хүртэл ЭМГ-ын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн даргаар ажиллаж байна.

Тус хэлтэс нь дараах чиг үүрэгтэй:

- ✚ Орон нутгийн түвшинд эмнэлгийн тусламж үйлчилгээний зорилт, стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлон мэргэжлийн удирдлага, үйл ажиллагааны нэгдсэн бодлогоор хангах.
- ✚ Хүн амын эрүүл мэндийн хамгаалах, дэмжих талаар гарсан Монгол улсын хууль тогтоомж, дүрэм, заавар, стандартыг мөрдлөгө болгон төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эрүүл мэндийн бодлогыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.
- ✚ Нутаг дэвсгэрийн түвшинд хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлон, түүнийг ямар тусламж үйлчилгээгээр хангах чиглэлээ тогтоох, хэрэгжүүлэх.
- ✚ Хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийж, зонхилон тохиолдож буй өвчин эмгэгийг илрүүлэн эмчлэх арга хэмжээг удирдан зохион байгуулах.
- ✚ Аймаг, сум сум дунд өрхийн болон хувийн хэвшлийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэл зүйн стандарт удирдамжийн хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах.



ДҮН ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТЭС



Дүн шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс нь Эрүүл мэндийн байгууллагуудын статистик мэдээллийн ажлыг сайжруулж, ажлын нэгдсэн удирдлага, арга барилаар ханган, мэдээллийг төвлөрүүлэх, статистик боловсруулалт, дүн шинжилгээ хийх, мэдээллээр хангахад чиглэсэн үйл ажиллагаа хариуцан ажилладаг.

Зоригт овогтой Оюунгэрэл нь 2009 онд ЭМШУҮИС-ын НЭМ-ийн сургуулийг Эрүүл мэндийн эдийн засагч, статистикч мэргэжлээр төгссөн. 2016 онд АШУҮИС-ын Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн магистрын зэрэг хамгаалсан.

2009-2014 оны хооронд Архангай аймаг Нэгдсэн эмнэлгийн Удирдлагын тасагт Статистикийн их эмчээр ажилласан.

2014-2016 онд Солонгос улсын Сежун их сургуулийн Солонгос хэлний сургуульд солонгос хэлний бэлтгэлд суралцсан.

2017 оноос одоог хүртэл ЭМГ-ын Статистик мэдээ, мэдээлэл мэдээний сан хариуцсан мэргэжилтэн, Статистикийн эрүүл мэндийн улсын байцаагчаар ажиллаж байна.

Тус хэлтэс нь дараах чиг үүрэгтэй:

- ✚ Эрүүл мэндийн тухай хууль болон Статистикийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, тушаал, заавар, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах
- ✚ Мэдээллийн технологийн төр засгийн бодлого, шийдвэр, холбогдох бусад хууль тогтоомж дүрэм журмыг хэрэгжүүлэх
- ✚ Эрүүл мэндийн байгууллагуудын статистик бүртгэл мэдээллийн үйл ажиллагааг удирдлага, мэргэжил арга зүйгээр хангах
- ✚ Эрүүл мэндийн байгууллагуудын статистик мэдээ, мэдээллийг төвлөрүүлэх, статистик боловсруулалт, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээллээр хангах
- ✚ Эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж буй систем, програм хангамжуудын заавар зөвлөгөө, хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах
- ✚ Хорт хавдрын бүртгэл тандалтын тогтолцоо болон эргэн дуудах тогтолцооны үйл ажиллагаанд холбогдох бүртгэлийн маягтуудыг үнэн зөв хөтлүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах, харъяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хорт хавдрын тохиолдлыг идэвхитэй хайх аргаар олж илрүүлэх, мэдээллэх

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТЭС



Хяналт шалгалтын хэлтэс нь Салбарын хяналтын чиглэлээр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх замаар болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнгийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг.

Магсаржалам овогтой Цагаандалай 1998 онд Анагаах ухааны их сургуулийг хүний их эмч мэргэжлээр төгссөн.

1998-1999 онуудад Архангай аймгийн Хашаат сумын хүн эмнэлэгт эрхлэгч эмчээр ажилласан.

2000-2001 онуудад Архангай аймгийн БГХӨТГ-т нян судлаач эмчээр ажилласан.

2001-2013 онуудад Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газарт эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагчаар ажилласан.

2013-2014 онд Архангай аймгийн Эрүүл мэндийн газарт суурь тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтнээр ажилласан.

2014-2022 онуудад Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газарт эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагчаар ажилласан.

2022 онд Мэргэжлийн хяналтын газрыг татан буулгах, улсын байцаагчдийг шилжүүлэн ажиллах Засгийн газрын тогтоолын дагуу 2023 оны 01 сараас одоог хүртэл Архангай аймгийн Эрүүл мэндийн газарт Эмчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагчаар ажиллаж байна.

Тус хэлтэс нь Эмчилгээний чанар, Халдвар судлалын эрүүл ахуй, Орчны эрүүл ахуй, Хүүхдийн эрүүл ахуй гэсэн 4 чиглэлийн хяналтын чиглэлээр дараах чиг үүрэгтэй:

- ✚ Орон нутгийн салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, бодлого, хөгжлийн стратегийг тодорхойлох, бодлогын баримт бичигт тусгуулах, жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.
- ✚ Салбарын хяналтын чиглэлээр батлагдсан эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт шалгалтын мэдээллийг цахим системд бүртгэх, хяналт шалгалт хийх объектыг төлөвлөх, батлуулах, хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгөх.
- ✚ Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх, нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан үүсгэх.
- ✚ Гамшиг, олныг хамарсан өвчлөл, онцгой байдлын үеийн хяналт шалгалтын төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах.
- ✚ Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах мэдээлэл, зөвлөмжөөр хангах.
- ✚ Холбогдох байгууллагатай тохиролцон зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор дээж авч итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулж, дүгнэлт гаргах
- ✚ Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих хууль, журмын дагуу хэрэгжүүлэх.
- ✚ Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу хуулиар тусгайлан олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх.